



Салбар байгуулах тухай

Компанийн үйл ажиллагаа өргөжин тэлж байгаатай холбогдуулан Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.14 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 6 сарын 14-ний өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор дор дурьдсан байршлуудад компанийн салбарыг нээж, үйл ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Сүхбаатарын гудамж, Төв шуудан, баруун хаалга хаягт байрлах Монгол Шуудан ХК-ийн байранд “Ард Кредит ББСБ ХК Төв шуудан салбар”;
 - Төв аймаг, Зуунмод сум, Хөшигийн хөндий, 41-100 хаягт байрлах Монгол Шуудан ХК-ийн байранд “Ард Кредит ББСБ ХК Нисэх салбар”
2. Салбар байгуулах болсонтой холбогдуулан Төв шуудан салбарын захирлаар Баттөгс овогтой Бэхнасан (РД:ТЕ78090172)-г, Нисэх салбарын захирлаар Чинбат овогтой Солонго (РД:ЧН84093063)-г тус тус томилсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Салбарын үйл ажиллагааг зохион байгуулж, үйл ажиллагаандаа компанийн зээлийн үйл ажиллагааны журам болон холбогдох бусад дүрэм, журмыг баримталж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Төв шуудан салбарын захирал Б.Баттөгс, Нисэх салбарын захирал Ч.Солонго нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж Санхүүгийн зохицуулах хорооноос Салбарын тусгай зөвшөөрөл авах материалыг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах, тусгай зөвшөөрөл авах, Салбаруудын захирлуудтай гэрээ байгуулах, салбарын ажиллагсдыг томилж, холбогдох дүрэм, журмыг батлахыг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороонд даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ